



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 24/14

Улаанбаатар хот

Удирдах зөвлөл болон Төлөөлөн
удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн
томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 35 дугаар зүйлийн 35.1.11, 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилж, хавсралтаар баталсугай.

2. Компанийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Удирдах зөвлөлийн ажиллах журам", "Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам" болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг томилогдсон гишүүдэд даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 17, 2021 оны 18, 19, 189, 192 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын, 2023 оны 53, 68, 71, 83, 108 дугаар тогтоол, 2024 оны 23, 46, 83, 84, 102, 118 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн хороо (Б.Сэмжидмаа)-нд даалгасугай.

ДАРГА

А.БАЯР